



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/227

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16 дугаар заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн үр дүнг олон нийтэд тайлагнах ажлын зардалд шаардагдах 19,200,000 (Арван есөн сая хоёр зуун мянга) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

